# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/033/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Т.Амармэнд
Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.5.1 Төсвийн төлөвлөлт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

3.5.3 Нэмэлт төсөв

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.23 № УвА-2026/033/ЧА-СТА-ТШЗ
танай_______________-ны №__________________-т

УВС НУУРЫН АЙ САВЫН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050467

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **191,711,526.48** | **373,778,384.80** |
| **33** | **АВЛАГА** | 69,724.88 | 157,887,848.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 307,133.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 157,580,715.00 |
| **335** | **Бусад авлага** | 69,724.88 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 69,724.88 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 191,641,801.60 | 215,890,536.80 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,247,500.00 | 11,247,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 11,247,500.00 | 11,247,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 180,394,301.60 | 204,643,036.80 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 149,500.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 180,244,801.60 | 204,643,036.80 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **593,937,427.59** | **739,019,547.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 593,937,427.59 | 739,019,547.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 577,585,494.26 | 723,090,258.46 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 328,766,546.00 | 328,766,546.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -63,136,390.72 | -73,809,238.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 300,958,704.21 | 430,791,594.25 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -142,845,251.05 | -188,202,944.89 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 222,856,107.67 | 253,627,069.64 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -78,771,362.13 | -83,794,353.54 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,699,788.09 | 23,699,788.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -14,758,314.80 | -11,847,083.34 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | -1,680,000.14 | -1,760,000.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,740,000.00 | 50,764,092.93 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -8,244,332.87 | -7,145,212.26 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,351,933.33 | 15,929,288.89 |
| 39301 | Програм хангамж | 1,267,933.33 | 1,267,933.33 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -422,644.44 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 15,084,000.00 | 15,084,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **785,648,954.07** | **1,112,797,932.15** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **11,121,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 11,121,000.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 11,121,000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 8,144,300.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 2,976,700.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 2,976,700.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **785,648,954.07** | **1,101,676,932.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 785,648,954.07 | 1,101,676,932.15 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263,231,402.00 | 263,231,402.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 263,231,402.00 | 263,231,402.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 501,239,970.10 | 817,267,948.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 501,239,970.10 | 501,239,970.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 316,027,978.08 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 21,177,581.97 | 21,177,581.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **785,648,954.07** | **1,112,979,932.15** |

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,471,643,177.72** | **1,482,927,525.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **284,642,837.72** | **470,436,425.33** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 284,642,837.72 | 470,436,425.33 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 284,642,837.72 | 470,436,425.33 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,545,000.00 | 166,225,715.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 275,097,837.72 | 304,210,710.33 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,187,000,340.00** | **1,012,491,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,064,187,900.00 | 954,168,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,064,187,900.00 | 954,168,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 122,812,440.00 | 58,322,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 23,020,300.00 | 8,385,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,997,400.00 | 49,937,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 69,794,740.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,319,870,129.48** | **1,168,014,809.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,319,870,129.48** | **1,168,014,809.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,171,589,887.84 | 1,120,302,296.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 788,131,355.00 | 785,075,422.51 |
| 210101 | Үндсэн цалин | 413,999,100.00 | 424,078,721.51 |
| 210102 | Нэмэгдэл | 219,933,592.00 | 236,969,851.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 90,110,463.00 | 71,200,000.00 |
| 210104 | Урамшуулал | 64,088,200.00 | 52,826,850.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 96,981,775.41 | 97,415,115.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,844,940.68 | 66,866,058.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,598,751.53 | 7,866,594.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,799,376.12 | 3,925,377.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,626,213.20 | 3,751,416.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,112,493.88 | 15,005,667.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,745,280.70 | 33,248,830.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,114,225.70 | 2,463,796.23 |
| 210302 | Түлш, халаалт | 20,119,968.00 | 29,399,040.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,511,087.00 | 1,385,994.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 45,317,161.37 | 24,609,759.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,560,850.00 | 1,087,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,205,380.00 | 16,562,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,765,481.37 | 3,480,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,800,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,985,450.00 | 3,480,059.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 62,361,600.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 62,361,600.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,000,000.00 | 1,614,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 1,614,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,514,000.00 | 15,716,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,514,000.00 | 15,716,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,115,519.16 | 14,978,351.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,574,530.16 | 12,916,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 101,550.00 | 461,160.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 388,791.00 | 542,391.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 89,848.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,378,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 150,800.00 | 150,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 103,423,196.20 | 147,644,217.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,110,959.40 | 868,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,205,692.00 | 13,284,741.80 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 74,106,544.80 | 133,491,076.05 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 148,280,241.64 | 47,712,512.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 114,125,832.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 78,771,832.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 35,354,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 34,154,409.64 | 47,712,512.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 34,098,778.03 | 47,708,525.11 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт | 55,631.61 | 3,987,68 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **151,773,048.24** | **317,819,115.60** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 1,791,137.52 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 1,791,137.52 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -1,791,137.52 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **151,773,048.24** | **316,027,978.08** |

## 2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,196,545,340.00** | **1,178,716,815.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,545,000.00** | **166,225,715.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,545,000.00 | 166,225,715.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 9,545,000.00 | 166,225,715.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,545,000.00 | 166,225,715.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,187,000,340.00** | **1,012,491,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,064,187,900.00 | 954,168,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,064,187,900.00 | 954,168,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 122,812,440.00 | 58,322,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 23,020,300.00 | 8,385,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,997,400.00 | 49,937,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 69,794,740.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,177,067,340.00** | **1,178,716,815.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,177,067,340.00** | **1,178,716,815.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,028,787,098.36** | **973,423,587.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 788,131,355.00 | 785,382,555.51 |
| 210101 | Үндсэн цалин | 413,999,100.00 | 424,593,125.51 |
| 210102 | Нэмэгдэл | 219,933,592.00 | 236,916,024.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 90,110,463.00 | 71,046,556.00 |
| 210104 | Урамшуулал | 64,088,200.00 | 52,826,850.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,051,500.29 | 97,345,390.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,914,665.56 | 66,796,333.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,598,751.53 | 7,866,594.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,799,376.12 | 3,925,377.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,626,213.20 | 3,751,416.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,112,493.88 | 15,005,667.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,745,280.70 | 33,248,830.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,114,225.70 | 2,463,796.23 |
| 210302 | Түлш, халаалт | 20,119,968.00 | 29,399,040.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,511,087.00 | 1,385,994.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 53,136,811.37 | 15,266,059.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,480,850.00 | 595,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,910,980.00 | 9,776,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,765,481.37 | 3,086,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,720,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,259,500.00 | 1,807,559.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,300,000.00 | 114,200.00 |
| 210602 | Тавилга | 1,300,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 114,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,514,000.00 | 7,800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,514,000.00 | 7,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,277,151.00 | 31,456,551.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,736,162.00 | 29,394,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 101,550.00 | 461,160.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 388,791.00 | 542,391.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 89,848.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,378,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 150,800.00 | 150,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,631,000.00 | 2,810,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,631,000.00 | 2,810,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **148,280,241.64** | **205,293,227.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 114,125,832.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 78,771,832.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 35,354,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 34,154,409.64 | 205,293,227.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 34,098,778.03 | 205,289,240.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,478,000.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,478,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,478,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 19,478,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,478,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-19,478,000.00** | **00.00** |

## 2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 263,231,402.00 | 21,177,581.97 | 349,466,921.86 | 00.00 | 633,875,905.83 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,231,402.00** | **21,177,581.97** | **349,466,921.86** | **00.00** | 633,875,905.83 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 151,773,048.24 | 00.00 | 151,773,048.24 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,231,402.00** | **21,177,581.97** | **501,239,970.10** | **00.00** | 785,648,954.07 |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **263,231,402.00** | **21,177,581.97** | **501,239,970.10** | **00.00** | 785,648,954.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,231,402.00** | **21,177,581.97** | **501,239,970.10** | **00.00** | 785,648,954.07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 316,027,978.08 | 00.00 | 316,027,978.08 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,231,402.00** | **21,177,581.97** | **817,267,948.18** | **00.00** | 1,101,676,932.15 |

## 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| ЭЗА | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 976,777,700.00 | 915,105,374.89 | 61,672,325.11 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 976,777,700.00 | 915,105,374.89 | 61,672,325.11 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 976,777,700.00 | 915,105,374.89 | 61,672,325.11 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 804,810,700.00 | 760,522,686.51 | 44,288,013.49 |
| 210101 | Үндсэн цалин | 426,861,500.00 | 424,593,125.51 | 2,268,374.49 |
| 210102 | Нэмэгдэл | 245,028,700.00 | 212,056,155.00 | 32,972,545.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 67,147,900.00 | 71,046,556.00 | -3,898,656.00 |
| 210104 | Урамшуулал | 65,772,600.00 | 52,826,850.00 | 12,945,750.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,018,600.00 | 94,272,047.35 | 2,746,552.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,990,300.00 | 64,683,244.54 | 1,307,055.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,764,400.00 | 7,617,996.28 | 146,403.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,882,200.00 | 3,801,078.30 | 81,121.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,876,400.00 | 3,633,945.59 | 242,454.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,505,300.00 | 14,535,782.64 | 969,517.36 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,249,200.00 | 33,248,830.23 | 1,000,369.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,778,000.00 | 2,463,796.23 | 314,203.77 |
| 210302 | Түлш, халаалт | 29,640,100.00 | 29,399,040.00 | 241,060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,831,100.00 | 1,385,994.00 | 445,106.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 17,916,500.00 | 11,851,059.80 | 6,065,440.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,855,000.00 | 595,100.00 | 1,259,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,582,800.00 | 6,406,600.00 | 1,176,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,909,700.00 | 3,086,800.00 | 1,822,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,827,600.00 | 00.00 | 1,827,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,741,400.00 | 1,762,559.80 | -21,159.80 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 114,200.00 | 114,200.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 114,200.00 | 114,200.00 | 00.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 4,780,000.00 | 4,380,000.00 | 400,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,780,000.00 | 4,380,000.00 | 400,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,828,500.00 | 10,656,551.00 | 7,171,949.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,699,500.00 | 8,594,200.00 | 5,105,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,800.00 | 864,000.00 | 800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 461,800.00 | 461,160.00 | 640.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 546,100.00 | 542,391.00 | 3,709.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 745,300.00 | 44,000.00 | 701,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,360,000.00 | 00.00 | 1,360,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 151,000.00 | 150,800.00 | 200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60000.00 | 60000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,000.00 | 60,000.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 976,777,700.00 | 915,105,374.89 | 61,672,325.11 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 968,132,700.00 | 906,460,374.89 | 61,672,325.11 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 968,132,700.00 | 906,460,374.89 | 61,672,325.11 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 8,645,000.00 | 8,645,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,645,000.00 | 8,645,000.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 27.00 | 25.00 | 02.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 17.00 | 03.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 07.00 | -01.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **58,318,212.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **58,318,212.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 58,318,212.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 24,859,869.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 24,859,869.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 3,073,343.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 2,113,088.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 248,598.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 124,299.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 117,471.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 469,885.21 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 3,415,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 3,370,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 45,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 3,420,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 3,420,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 20,800,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 20,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 2750000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,750,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 58322200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 58,322,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 8,385,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 49,937,200.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь Увс нуурын ай савын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль хамгааллын арга хэмжээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тогтвортой байгальд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэн байгаль, түүхийн соёлын өвийг унаган төрхөөр нь хадгалж хойч үедээ өвлүүлэн үлдээхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 328,940.1 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 69.7 | 157,887.9 | 157,818.2 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 191,641.8 | 215,890.5 | 24,248.7 |
| Үндсэн хөрөнгө | 593,937.4 | 739,019.5 | 145,082.1 |
| **Нийт хөрөнгө** | **785,648.9** | **1,112,797.9** | **327,149.0** |
| Өр төлбөр | 0.0 | 11,121.0 | 11,121.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 785,648.9 | 1,101,676.9 | 316,028.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **785,648.9** | **1,112,797.9** | **327,149.0** |

Авлага дансны үлдэгдэл 157,887.9 мянган төгрөг болж 157,818.2 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалаар үйл ажиллагааны давсан орлогыг авлагад тооцон бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 215,890.5 мянган төгрөг болж 24,248.7 мянган төгрөгөөр өссөн нь Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлийн яамнаас үнэ төлбөргүй хүлээн авсан 23,846.4 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 739,019.5 мянган төгрөг болж 145,082.1 мянган төгрөгөөр өссөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлийн яамнаас шилжүүлсэн 153,346.9 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 33,250,3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 43,264.1 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө тус тус нэмэгдсэн, тайлант оны 133,491.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 1791,1 мянган төгрөгний үндсэн хөрөнгө худалдсаны гарзны зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,121.0 мянган төгрөг болж 11,121.0 мянган төгрөгөөр өссөн нь шуудан холбооны 393.9 мянган төгрөг, тээвэр шатахууны 4,990.4 мянган төгрөг, дотоод албан томилолтын 2,760.0 мянган төгрөг, байгууллагад төлөх 2,976.7 мянган нийт 11,121,0 мянган төгрөгийн өр төлбөр гүйлгээний эрх хязгаарлаж, санхүүжилт татагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,112,797.9 мянган төгрөг болж 327,149.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,079,608.2 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 8,645.0 мянга нийт 1,088,253.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,088,253.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хүргүүлсэн саналаар нь буюу 1,088,253.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 111,475.5 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 968,132,7 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоор 8,645.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 915,105.4 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа зарлагын гүйлгээний эрх хязгаарласан болон 80219, 81703 хөтөлбөр арга хэмжээний санхүүжилт татагдсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71405-Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 80101-Үйл ажиллагааны зардал | 954,433.2 | 906,511.2 | 8,858.8 | 99.1% |
| 2 | 71405-Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 80219-Харуул, хамгаалалтын зардал | 5.3 | 0.0 | 5.3 | |
| 3 | 71405-Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 81701- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 11,694.2 | 8,594.2 | 3,099.9 | 73.5% |
| 4 | 71405-Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 81703- Ургамал хамгаалал | 2,000.0 | 0.0 | 2,000.0 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

*/мянган төгрөг/*

| № | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Программ хангамжийн бүртгэл | 1,267.9 | санхүүгийн CTS программын балансын үнэ |
| 2 | Унаа, хоолны зардал | 71,046.6 | 2025 онд 71,046.6 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Сургалт, семинар | 13,775.0 | Сургалтын зардлаас тайлант онд 13,775.0 мянган төгрөгийн сургалтын зардал гарсан байна. |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээ | 0.0 | Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | 0.0 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна. |
| 6 | Хэвлэл мэдээлэл | 0.0 | Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна. |
| 7 | Орон тоо | 760,522.7 | Тайлант онд 27 орон тоотой ажиллахаар батлагдсанаас 25 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна. |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны нэмэлт нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 8,385.0 мянга, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 49,937.2 мянга, нийт 58,322.2 мянган төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4* Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бараа материал худалдан авахад 46,279.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 1,319,807.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,198.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,168,014.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,680.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,344.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 543,516.2 мянган төгрөгийн 14 гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 7 шийдвэрийг байршуулаагүй, мөн байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд шууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.2 дахь заалтад “Дэд дарга, орлогчгүй, эсхүл эзгүй тохиолдолд байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх”, 43.3.3 дахь заалтад “Энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх” гэж заасан байхад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/2 дугаар тушаалаар Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилсон байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 10, 11 дүгээр хавсралтаар цалинжих төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/33 дугаар тушаалаар 20 хувиар нэмэгдүүлэн тогтоож 24,950.1 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын гаргасан энэхүү шийдвэрээр Засгийн газрын тогтоосон хувь хэмжээг нэмэгдүүлэн тогтоох эрх хэмжээ байгаа эсэхийг төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 549,998.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 3,982.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 543,516.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг тус тус өглөө.

**Залруулсан алдаа:**

1. Хоёр албан хаагчдад 9,10 дугаар сард нийт 307.1 мянган төгрөгийн цалинг илүү олгож суутган тооцоогүй, авлагаар бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт " Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь заалтад "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн тул санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулга хийлгэлээ.
2. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас сумдад хийсэн сургалт, томилолтын зардалд 3,675.0 мянган төгрөг зарцуулсныг санхүүгийн үр дүнгийн тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан байсан нь Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул үр дүнгийн тайланд залруулга хийлгэлээ.

### 5.2 Зөвлөмж-1

*<u>Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлоготой холбоотой</u>*

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.10-д "Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах

эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэж заасныг зөрчин 8 дугаар сарын цахилгааны төлбөр тооцооны үлдэгдэл 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бэлнээр төлсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.10-д заасан "Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэснийг мөрдөж ажиллах.

**Зөвлөмж-2**

*Илрүүлэлт: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой.*

Илрүүлэлт:

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 543,516.2 мянган төгрөгийн 14 гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 7 шийдвэрийг байршуулаагүй, мөн байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд шууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа | 2 | 3,982.1 | 1 | 307.1 | 1 | 3,675.0 | 2 | 3,982.1 | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 8 дугаар сарын цахилгааны төлбөр тооцооны үлдэгдэл 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бэлнээр төлсөн байна. | 1 | 500.0 | | | | | 1 | 500.0 | | | | |
| **Дүн** | **1** | **500.0** | | | | | **1** | **500.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 1 | 543,516.2 | | | | | 1 | 543,516.2 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **543,516.2** | | | | | **1** | **543,516.2** |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Т.АМАРМЭНД/

2026 оны 02 сарын 23-ны өдөр